

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 457-р нээлттэй, хаалттай хорих ангийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545

цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Албан шаардлага .....	
4.3 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагаравь баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ГАЗРЫН 457-р ХОРИХ АНГИЙН ДАРГА  
ДЭД ХУРАНДАА Б.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2022.02.22 № 2/55  
Ташай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГГ-ын 457-р хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГГ-ын 457-р хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.ВОЛДБААТАР

021020277

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Төгрөгөөр

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>137,575,449</b>	<b>176,243,191</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	910,000	4,117,056
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	910,000	4,117,056
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	910,000	4,117,056
31211	Төрийн сангийн харилцах	910,000	4,117,056
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,430,000	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	200,000	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,230,000	-
3351	Байгууллагаас авах авлага	1,230,000	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>135,235,449</b>	<b>172,126,135</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	37,277,620	63,097,666
35110	Тусгай зориулалттай материал	36,791,070	58,434,570
35130	Эм боох материал	486,550	4,663,096
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	97,957,829	109,028,469
35410	Бичиг хэргийн материал	996,865	547,515
35420	Аж ахуйн материал	56,979,338	62,097,569
35440	Түлш, шатах тослох материал	4,552,850	66,680
35450	Барилгын засварын материал	2,267,000	1,626,550
35460	Хүнсний материал	5,541,777	8,188,555
35470	Бусад хангамжийн материал	1,200,000	561,600
35600	Мал амьтад	26,420,000	35,940,000
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,787,243,086</b>	<b>1,725,050,861</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,787,243,086	1,725,050,861
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,518,950,686	1,456,758,461
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,483,537,074	1,483,537,074
39202	Хуримтлагдсан элэгдэл	(116,084,137)	(164,638,945)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	209,355,809	169,809,000
39204	Хуримтлагдсан элэгдэл	(189,855,809)	(153,684,000)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	180,069,820	189,782,545
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,302,349)	(102,395,477)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,843,466	40,997,085
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,614,987)	(20,507,751)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	5,846,324	5,846,324
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,787,021	11,787,021
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,631,546)	(3,774,416)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	268,292,400	268,292,400
39301	Програм хангамж	6,417,692	6,417,692
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,417,692)	(6,417,692)
39303	Бусад биет бус хөрөнгө	268,292,400	268,292,400
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,924,818,535</b>	<b>1,901,294,052</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,140,000</b>	<b>17,866,200</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,140,000	17,866,200
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,140,000	17,866,200
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,140,000	17,866,200
41361	Байгууллагад төлөх өглөг	480,000	17,676,200

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,660,000	190,000
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,922,678,535</b>	<b>1,883,427,852</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,922,678,535	1,883,427,852
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	500,863,282	500,863,282
51101	Өмч: - төрийн	500,863,282	500,863,282
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	791,584,949	752,428,631
51210	Өмнөх үеийн үр дүн	791,584,949	791,679,314
51220	Тайлант үеийн үр дүн	-	(39,250,683)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	630,230,303	630,135,938
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,924,818,535</b>	<b>1,901,294,052</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,298,183,575</b>	<b>1,398,043,001</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>159,409,475</b>	<b>116,337,061</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	159,409,475	116,337,061
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	159,409,475	116,337,061
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,624,515	50,095,400
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93,784,960	66,241,661
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,138,774,100</b>	<b>1,281,705,940</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,111,174,100	1,130,377,900
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,111,174,100	1,130,377,900
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27,600,000	74,528,040
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,600,000	1,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	21,056,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		52,472,040
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	76,800,000
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		76,800,000
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,306,966,399</b>	<b>1,437,293,685</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,306,966,399</b>	<b>1,437,293,685</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,269,983,443	1,397,473,612
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	887,568,853	871,873,745
210101	Үндсэн цалин	607,490,009	588,353,525
210102	Нэмэгдэл	274,078,844	278,060,220
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,000,000	2,340,000
210104	Урамшуулал	1,000,000	3,120,000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,631,600	21,859,055

210201	Тэтгэврийн даатгал	-	1,023,370
210202	Тэтгэмжийн даатгал	-	120,396
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	133,800
210204	Ажилгүйдлийн даатгал	-	24,079
210205	Эрүүл мэндийн даатгал	11,631,600	20,557,409
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	98,423,740	82,929,270
210301	Гэрэл, цахилгаан	40,000,000	38,866,600
210302	Түлш, халаалт	44,418,740	32,658,370
210303	Цэвэр, бохир ус	14,005,000	11,404,300
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	42,339,555	61,197,727
210401	Бичиг хэрэг	4,820,441	6,577,450
210402	Тээвэр, шатахуун	16,981,300	23,247,300
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,985,200	4,263,825
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,936,397	16,134,151
210408	Бараа материал акталсны зардал	8,616,217	10,975,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	118,455,044	84,588,994
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,566,116	7,546,504
210502	Хоол, хүнс	82,189,352	68,866,621
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,699,576	8,175,869
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,416,100	83,704,543
210604	Урсгал засвар	18,416,100	83,704,543
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	496,000	1,300,000
210702	Дотоод албан томилолт	496,000	1,300,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,127,190	78,138,281
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,320,290	73,761,307
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000	461,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	934,000	247,474
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000	144,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500	554,500
210807	Газрын төлбөр	4,675,400	2,970,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	80,525,361	111,881,998
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	567,730	32,891,790
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,957,631	78,990,208
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	36,982,956	39,820,073
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	5,056,000	5,056,000
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	5,056,000	5,056,000
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	492,000	2,515,200
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	492,000	2,515,200

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,397	73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,397	73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,420,559	32,248,800
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,420,559	32,248,800
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>(8,782,824)</b>	<b>(39,250,684)</b>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>(8,782,824)</b>	<b>(39,250,684)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	500,863,282	630,736,207	795,077,070	1,926,676,559
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	600,268	600,268
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>500,863,282</b>	<b>630,736,207</b>	<b>795,677,339</b>	1,927,276,828
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	-600,268	0	-600,268
C07	Тайлант үеийн үр дүн			-3,998,024	-3,998,024
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>500,863,282</b>	<b>630,135,938</b>	<b>791,679,314</b>	1,922,678,535
D01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>500,863,282</b>	<b>629,535,670</b>	<b>787,681,290</b>	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	94,365	94,365
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>500,863,282</b>	<b>630,135,938</b>	<b>791,773,679</b>	1,922,772,900
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	-94,365	0	-94,365
D08	Тайлант үеийн үр дүн			-39,250,683	-39,250,683
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>500,863,282</b>	<b>630,041,573</b>	<b>752,522,996</b>	1,883,427,852

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<b>1,312,839,206</b>	<b>1,332,121,340</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>170,195,106</b>	<b>52,325,400</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	170,195,106	52,325,400
120,004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	170,195,106	50,095,400
1,200,042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,195,106	50,095,400
120,009	Бусад орлого	-	2,230,000
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,142,644,100</b>	<b>1,279,795,940</b>
1,310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,111,174,100	1,130,377,900
131,001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,111,174,100	1,130,377,900

<b>1,311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,470,000	72,618,040
131,103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,370,000	51,562,040
131,104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	21,056,000
<b>1,320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	76,800,000
132,007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		76,800,000
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,297,679,206</b>	<b>1,328,914,284</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,297,679,206</b>	<b>1,328,914,284</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,260,696,250</b>	<b>1,287,288,211</b>
<b>2,101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	887,568,853	875,800,800
210,101	Үндсэн цалин	607,490,009	589,394,800
210,102	Нэмэгдэл	274,078,844	280,946,000
210,103	Унаа хоолны хөнгөлөлт	5,000,000	2,340,000
210,104	Урамшуулал	1,000,000	3,120,000
<b>2,102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,631,600	21,859,055
210,201	Тэтгэврийн даатгал	-	1,023,370
210,202	Тэтгэмжийн даатгал	-	120,396
210,203	ҮОМШӨ-ний даатгал	-	133,800
210,204	Ажилгүйдлийн даатгал	-	24,079
210,205	Эрүүл мэндийн даатгал	11,631,600	20,557,409
<b>2,103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	100,004,950	78,925,500
210,301	Гэрэл, цахилгаан	40,000,000	38,866,600
210,302	Түлш, халаалт	45,999,950	28,654,600
210,303	Цэвэр, бохир ус	14,005,000	11,404,300
<b>2,104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,556,000	36,498,399
210,401	Бичиг хэрэг	4,444,300	4,367,200
210,402	Тээвэр, шатахуун	15,588,700	22,674,900
210,403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,985,200	4,204,825
210,405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	92,600	80,000
210,406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,445,200	5,171,474
<b>2,105</b>	<b>Нормативт зардал</b>	78,100,600	72,228,900
210,501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,000,600	8,675,500
210,502	Хоол, хүнс	72,100,000	63,553,400
<b>2,106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,487,200	99,848,891
210,601	Багаж, техник, хэрэгсэл	13,519,400	15,759,400
210,603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000	2,000,000
210,604	Урсгал засвар	18,967,800	82,089,491

<b>2,107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	496,000	1,300,000
210,702	Дотоод албан томилолт	496,000	1,300,000
<b>2,108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>116,786,647</b>	<b>80,295,667</b>
210,801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,979,747	72,879,693
210,802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000	461,000
210,804	Тээврийн хэрэгслийн татвар	934,000	286,474
210,805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000	144,000
210,806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500	554,500
210,807	Газрын төлбөр	4,675,400	5,970,000
<b>2,109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,064,400</b>	<b>20,531,000</b>
210,901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,729,900	20,196,500
210,902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	334,500	334,500
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,982,956</b>	<b>41,626,073</b>
<b>2,131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>5,056,000</b>	<b>5,056,000</b>
213,101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	5,056,000	5,056,000
<b>2,132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>492,000</b>	<b>4,321,200</b>
213,209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	492,000	4,321,200
<b>2,133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,397</b>	<b>73</b>
213,301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,397	73
<b>2,135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>31,420,559</b>	<b>32,248,800</b>
213,503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,420,559	32,248,800
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>15,160,000</b>	<b>3,207,056</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>910,000</b>	<b>3,207,056</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	910,000
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>910,000</b>	<b>4,117,056</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,156,724,500	1,156,724,427
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,156,724,500	1,156,724,427
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,154,103,300	1,149,047,187
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	875,800,800	875,800,800

210101	Үндсэн цалин	589,394,800	589,394,800
210102	Нэмэгдэл	280,946,000	280,946,000
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,340,000	2,340,000
210104	Урамшуулал	3,120,000	3,120,000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,859,100	21,859,055
210201	Тэтгэврийн даатгал	-	1,023,370
210202	Тэтгэмжийн даатгал	-	120,396
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	133,800
210204	Ажилгүйдлийн даатгал	-	24,079
210205	Эрүүл мэндийн даатгал	21,859,100	20,557,409
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	78,925,500	75,688,078
210301	Гэрэл, цахилгаан	38,866,600	35,629,218
210302	Түлш, халаалт	28,654,600	28,654,560
210303	Цэвэр, бохир ус	11,404,300	11,404,300
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,367,400	30,821,781
210401	Бичиг хэрэг	5,300,000	4,367,200
210402	Тээвэр, шатахуун	14,543,600	13,760,900
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,211,200	7,442,207
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	92,600	80,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,220,000	5,171,474
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	72,228,900	73,276,900
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,675,500	8,675,500
210502	Хоол, хүнс	63,553,400	64,601,400
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	53,917,200	53,652,200
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,759,400	14,494,400
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000	2,000,000
210604	Урсгал засвар	37,157,800	37,157,800
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,300,000	1,300,000
210702	Дотоод албан томилолт	1,300,000	1,300,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,842,400	13,842,374
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,426,400	6,426,400
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	461,000	461,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	286,500	286,474
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	144,000	144,000

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500	554,500
210807	Газрын төлбөр	5,970,000	5,970,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,806,000</b>	<b>2,806,000</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,471,500	2,471,500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	334,500	334,500
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,056,000</b>	<b>7,677,240</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>5,056,000</b>	<b>5,056,000</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,621,200	5,056,000
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,621,200</b>	<b>2,621,240</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,621,200	4,321,200
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,156,724,500</b>	<b>1,156,724,427</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,156,724,500</b>	<b>1,130,377,827</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,130,377,900	1,130,377,900
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>26,346,600</b>	<b>26,346,600</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,346,600	26,346,600
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>27,070,000</b>	<b>138,152,675</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,820,000</b>	<b>125,227,675</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>12,820,000</b>	<b>125,227,675</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	53,914,202
210105	Гэрээт ажлын хөлс		53,914,202
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	6,273,740
210301	Гэрэл, цахилгаан		6,273,740
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,000,000</b>	<b>13,347,000</b>
210402	Тээвэр, шатахуун	1,000,000	8,131,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,216,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,320,000</b>	<b>39,731,951</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,120,000	1,000,000
210604	Урсгал засвар	2,200,000	38,731,951

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	11,960,782
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	11,670,412
210803	Даатгалын үйлчилгээ		290,400
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,250,000</b>	<b>12,925,000</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	14,250,000	12,925,000
223001	Бусад хөрөнгө		12,925,000
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	26,370,000	141,359,731
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,370,000	141,359,731
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,370,000	68,741,691
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	21,056,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		51,562,040
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		910,000
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,117,056

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 457-р хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд орлого төвлөрүүлэлт, төсвийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 02 дугаар сарын 08-нөөс 2021 оны 02 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 01/152 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр болон бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх,*
- ✓ *Хорих ялыг нээлттэй, хаалттай хорих ангид ял эдлүүлэх, цагдан хорих ажиллагааг зохион байгуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх,*
- ✓ *Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах,*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- *ШШГГГ-ын 2020 оны 12-р сарын 30-ны А/211 тоот тушаалаар 2021 оны төсвийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Прокурорын газраас 2021 онд ялтны нэрийн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 457-р хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1318.9 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 13.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 457-р хорих ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94.6 сая төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд төрийн сангийн харилцах дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 172.1 сая төгрөг болж 36.8 сая төгрөгөөр өссөн нь малын нас дэвшилтийн орлогоос 9.5 сая төгрөг, хүнсний материал 2.6 сая төгрөг, аж ахуйн материал 5.1 сая төгрөг, тусгай зориулалтын материал 19.6 сая төгрөгөөр шинэчилсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 243.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 59.8 сая төгрөгөөр нийт 317.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 280.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын данс оны эхэнд 1.4 сая төгрөг байснаас оны эцэст бүрэн барагдаж авлагын үлдэгдэлгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2207.1 сая төгрөг байсан бол оны эцэст 2176.4 сая төгрөг болж 30.7 сая төгрөгөөр буурсан нь байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2207.1 сая төгрөг байсан бол оны эцэст 2176.4 сая төгрөг болж 30.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 10.4 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 6.4 сая төгрөгийн хөрөнгө орлого авч ТӨХБЗГ-ын 564 тоот тогтоолоор 39.5 сая төгрөг, ШШГГГ-ын 06/2565 тоот тушаалаар 7.9 сая төгрөг нийт 47.5 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна. Тайлант оны эцэст 1725.0 сая төгрөгийн цэвэр хөрөнгийн үлэгдэлтэй байна

Тайлант оны эцэст 17.8 сая төгрөгийн өр үүссэн байгаа нь ШШГГГ-аас буцаан төвлөрүүлэх хөрөнгийн өр 17.7 сая, хүмүүст буцаан олгох 0.1 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 500.8 сая төгрөг байсан оны эцэст 500.8 сая төгрөг болж тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хөрөнгийн дахин үнэлгээний бууралт 94.3 мянган төгрөг хаасан бичилт хийсэн, тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 752.4 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

ШШГГ-ын 457-р хорих анги нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн санхүүжилтээр 1088.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 21.3 сая төгрөг нийт 1109.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1109.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ШШГЕГ-аас тус байгууллагын төсвийг төсвөөс 1088.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 21.3 сая төгрөг нийт 1109.4 сая төгрөг батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1109.4 сая төгрөгийн төсөв баталснаас 1108.1 сая төгрөгийг улсын төсвөөс 21.3 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ШШГЕГ-аас тушаал шийдвэргүй төсвийн тодотгол хийн төсвийн санхүүжилтийг 1130.4 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 26.3 сая төгрөг нийт 1156.7 сая төгрөгөөр буюу 47.3 сая төгрөгөөр урсгал зардалд өөрчлөлт хийн нэмэгдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1156,7 сая төгрөг буюу 100 хувь зарцуулж төсвийн хэмнэлт гаргаагүй тайлант оны үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 76.8 сая төгрөг, ШШГЕГ-аас 21.0 сая төгрөг, бусад 2.2 сая төгрөг нийт 100.0 сая төгрөг, гэрээний төлбөрийн орлогоос 36.5 сая төгрөг, ялтны нэрийн дансаар 14.9 сая төгрөг нийт 143.2 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсноор Улаан бүрд ХХК-аас тус байгууллагад мужааны цехийн тоног төхөөрөмж суурилуулж үйл ажиллагаа явуулж байгаа ч орлого зарлагын тооцоо хийж өглөг авлага тооцоогүй асуудал байна. Тус хөрөнгийг 2019 онд тухайн

байгууллагад хүлээлгэн өгсөн боловч төлбөрийн асуудал шийдэгдээгүйгээс хөрөнгө орлого аваагүй байгаа гэсэн тайлбар өгч байгаа тул дараагийн аудитаар авч үзэх.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал нь Аймгийн ОНХС-аас Цайны зам цогцолбор байгуулах, талбайн тохижилтын 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус байгууллага ШХА-2021/56 тоот гэрээ хийн хэрэгжүүлсэн нь ТБОНӨБҮХАТ хуулийг зөрчсөн, зураг төсөв бодитоор хийгдээгүй, ЗХЗ-суутгаагүй 1.5 сая төгрөг, төсөвт зургийн үнийг 80.0 мянгаар төсөвлөөд 280.0 мянган төгрөг шилжүүлсэн, Ажлаа бүрэн хийж дуусгаагүй байхад хүлээн авсан, хөрөнгө орлого авсан шийдвэр байхгүй, ажлаа бүрэн хийгээгүй, зарим хөрөнгө тус байгууллагын агуулахад хадгалагдаж байгаа, Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зардлаас төсвийн орлого бүрдүүлэн 8.5 сая төгрөг ШШГГ газарт төвлөрүүлсэн байна. Гүйцэтгэлийн аудитаар авч үзэх.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 151 хугацаандаа мэдээлэл оруулсан боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбарыг бичээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:** Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 158.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 зөвлөмж өгч 158.4 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

### **4.1 Залруулсан алдаа**

#### **1.1 Орлого, үр дүнтэй холбоотой**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

*Илрүүлэлт:* Орлого үр дүнгийн тайланд 79.1 сая төгрөгөөр орлого дутуу илэрхийлсэн, мөнгөн гүйлгээний тайланд 3.9 сая төгрөгийн орлого илүү илэрхийлсэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд 75.3 сая төгрөгийн орлого илүү хүлээн зөвшөөрсөн нийт 158.4 сая төгрөг,

*Шийдвэрлэлт:* Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 158.4 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан алдааг 2022 оны „, дугаар сарын „,-ны „, тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

## **4.2 Төлбөрийн акт**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1.2 Түрээстэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Төрийн өмчийн байр түрээслээд түрээсийн орлогын 40%-ийг Төрийн өмчийн дансанд төвлөрүүлээгүй

*Шийдвэрлэлт:* Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 03-р сарын 06-ны өдрийн 293 тоот тогтоолын 3.5-д "Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 40 хувийг төлбөр орсноос хойш 5 хоногийн дотор төсөвт төвлөрүүлнэ" гэж заасны дагуу төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад бүрэн барагдуулсан

## **4.4 Зөвлөмж**

### **1.10 Үйл ажиллагаатай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Засгийн газрын 261-р тогтоолын дагуу үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч, ял эдэлж байгаа хоригдлуудын хоолны норм нормативыг баримталж илчлэг хоолоор хангаагүй, хоолны зардлыг төсөвт бүрэн тусгаагүй

*Өгсөн зөвлөмж:* Хууль журмын дагуу норм нормативыг баримталж ажиллах эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ШШГГ-ын 457-р хорих анги	3	158.4	1	157.4	1	0.9	0	0	1	0

**ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**